



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 дугаар сарын 29

Дугаар 19/04

Баян-Өндөр сум

Г Ажлын албаны бүтэц, орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалт, 11.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай" 376 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол, 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөх тухай" 84 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Ажлын албаны бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зарим албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн Албаны Зөвлөлд хүргүүлж зөвшөөрөл авах, батлах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Ганзориг)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 66 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын 2024 оны 04 дугаар сарын 29-ний өдрийн Эзлэхийт Хуралдааны 29/дугаар тогтоолын хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

